

**“Э-ТРАНС ЛОЖИСТИКС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2018.04.11

Улаанбаатар хот

“Э-Транс Ложистикс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2018 оны 04 сарын 11-ний өдөр “БидиСЕК ҮЦК” ХК-ийн хурлын танхимд 10цагаас эхлэв.

“Э-Транс Ложистикс” ХК нь нийт саналын эрх бүхий 46,200,000 ширхэг хувьцаатай.

Нийт саналын эрх бүхий хувьцааны 93.42% буюу 43,159,011 ширхэг хувьцаа эзэмшиж буй 12 хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнтэйгээр хурал эхлэв.

Хуралд ирсэн хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар Чулуун овогтой Энхболд хурлын даргаар сонгогдон хурлыг нээн, хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулав. Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц:

№	Нэр	Хувьцааны тоо	Хувь
1	MONGOLIAN TRANSPORTATION HONDINGS SARL	3,200,000	6.93%
2	MONGOL TRANSPORTATION SARL	1,917,579	4.15%
3	BDPEF	1,818,857	3.94%
4	БИДИСЕК ҮЦК ХК	13,117,307	28.39%
5	Д.МӨНХТӨР	3,883	0.01%
6	Б.ЦЭРЭНЖАВ	170	0.00%
7	Э-ТРАНС	23,100,000	50.00%
8	НАМУУНДАРЬ	909	0.00%
9	ЦОЛМОН	10	0.00%
10	ШИГШЭЭ	276	0.00%
11	ДОВУУЧ	10	0.00%
12	ГАРАМХАНД	10	0.00%

Хурлаар хэлэлцэх асуудлууд:

- a) Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт
- b) Компанийн 2017 оны үйл ажиллагааны тайлан
- c) Компанийн 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах
- d) Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт бүхий тайланг батлах
- e) ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
- f) ТУЗ-ийн 2018 оны цалин урамшууллын төсөв батлах
- g) Хурлын дэгийн дагуу Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлуудаа хэлэлцэж дууссаны дараагаар санал асуулга хүлээн авахаар тохирлоо

Амарсанаа гишүүн:

“Э-транс ложистикс” ХК-ийн 2017 оны үйл ажиллагааны тайланг танилцууллаа. Тэрээр “2017 онд хийж гүйцэтгэсэн ачаа шилжүүлэн ачих үйл ажиллагаа өмнөх жилүүдэд зохион байгуулсан шилжүүлэн ачих үйл ажиллагаанаас эрс багассан үзүүлэлттэй байгаа. Энэ нь өмнөх жилүүдийн

адил улс орны эдийн засгийн хүндрэлтэй байдал, иргэд аж ахуйн нэгжийн худалдан авах чадварын бууралт зэрэг гадаад хүчин зүйлсээс үүдэлтэй юм. Барилгын салбар дахь гол хэрэглэгдэхүүн цементийн хэрэгцээг дотоодын үйлдвэрүүд хангах болж цементийн импорт зогссон нь өмнөх жилүүдэд шилжүүлэн ачсан ачааны тоо хэмжээг эрс багасгасан. Үүнтэй холбоотойгоор компани 2017 онд 382 сая төгрөгний алдагдалтай ажилласан.” Мөн тэрээр 2018 оны үндсэн үйл ажиллагаа болон гаалийн хяналтын бүс баталгаат агуулахын үйл ажиллагааг зохион байгуулах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг сайжруулах, сургалт нийгмийн хамгааллын хүрээнд хийгдэх ажил гэх мэт компаний төлөвлөгөө, танилцуулав.

Энхболд гишүүн:

Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт бүхий тайланг танилцуулав.

Тэрээр ТУЗ-ийн дүгнэлт төлөвлөөний биелэлт сайн гараагүй хэдий ч нийгэм эдийн засгийн хямрал төлөв байдал хүндхэн байгаа нөхцөлд үйл ажиллагааг үргэлжлүүлэн явуулсаар байгаа нь сайн байна гэж үзсэн. Мөн тэрээр ТУЗ-ийн 2018 оны цалин урамшууллын төсөв батлах асуудлыг танилцуулсан. ТУЗ-ий гишүүдэд цалин байдаггүй. Зөвхөн нарийн бичиг, болон хурал хуралдахтай холбоотой зардлууд байгаа

Төлөөлөн удирдах зөвлөлд өмнөх гишүүдээс Пүрэвбаатар гишүүний оронд Мянганбаяр нэр дэвшиж байгааг хэлсэн юм.

Ингээд хэлэлцэх асуудлын танилцуулга дууссанаар асуулт хариултын үйл ажиллагаа эхэлсэн юм.

Хувьцаа эзэмшигч Цэрэнжав:

Одоо хийсэн байгаа ажлын гэрээ бий юу?

Энхболд гишүүн:

Бий. Өмнөх хийсэн гэрээнүүд хүчинтэй хэвээрээ байгаа. Гол нь тэдгээр байгууллагууд тээвэр хийхгүй царцсан байдалтай байгаа. Манай компаний хувьд үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулсаар байгаа.

Хувьцаа эзэмшигч Цэрэнжав:

Одоо яг хэдэн хувьцаа эзэмшигчтэй вэ?

Хурлын комисс: 317 хувьцаа эзэмшигчтэй байгаа.

Хувьцаа эзэмшигч Цэрэнжав:

Одоо явуулж байгаа үйл ажиллагаанаас өөр хийхээр төлөвлөсөн ажил юу байна вэ? Ачаа хадгалах агуулахаа хүнсний чиглэлийн бүтээгдэхүүн халгалах болгож өөрчилөх боломж бий юу?

Амарсанаа гишүүн:

Байгаа. Нэмэлтээр тоноглоод болно. Гэхдээ тэр маань байнгын хүнс хадгална гэсэн зүйл байхгүй шүү дээ. Өөр хийх ажлыг бид судалж байгаа.

Хувьцаа эзэмшигч Шигшээ:

Э-транс компаний салбараа нээж болох уу? Гачууртын боомт дээр салбараа нээснээр уул уурхайн компаниудын урагшаа зөөж байгаа ачаа тээврийг хийж болно шүүдээ.

Энхболд гишүүн: тэр маань төмөр замаас хол авто тээвэр хийнэ гэсэн үг л дээ. Бид энэ талаар судалж байгаа.

Хувьцаа эзэмшигч Цэрэнжав:

Монголын компаниудтай холбоотой ажиллах хэрэгтэй.

Хувьцаа эзэмшигчдийн асуулт хариулт, санал хэлэх үйл ажиллагаа дуусч санал хураах үйл ажиллагаа эхлэв.

Санал хураалтаар нийт хувьцааны 93.42% буюу 43,159,011 ширхэг хувьцаа эзэмшиж буй 12 хувьцаа эзэмшигч саналын хуудас бөглөн өгсөн.

Үүний дараагаар тооллогын комиссын тогтоолыг танилцуулсан.

Хэлэлцэх асуудал 1:

Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах асуудлыг хуралд оролцож байгаа саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчдийн 0% татгалзсан, 0% түдгэлзсэн, 100% зөвшөөрсөн саналаар батлав.

Хэлэлцэх асуудал 2:

Компанийн 2017 оны үйл ажиллагааны тайланг батлах асуудлыг хуралд оролцож байгаа саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчдийн 0% татгалзсан, 0% түдгэлзсэн, 100% зөвшөөрсөн саналаар батлав.

Хэлэлцэх асуудал 3:

Компанийн 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах асуудлыг хуралд оролцож байгаа саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчдийн 0% татгалзсан, 0% түдгэлзсэн, 100% зөвшөөрсөн саналаар батлав.

Хэлэлцэх асуудал 4:

Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт бүхий тайланг батлах асуудлыг хуралд оролцож байгаа саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчдийн 0% татгалзсан, 0% түдгэлзсэн, 100% зөвшөөрсөн саналаар батлав.

Хэлэлцэх асуудал 5:

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг кумулятив аргаар сонгох тухай асуудлаар хуралд оролцож байгаа саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчдийн өгсөн саналын дүнг үндэслэн дараах гишүүд ТУЗ-ийн гишүүд сонгогдсон.

А. Ердийн гишүүнд өгсөн санал:

№	Нэр дэвшигчдийн нэрс	Саналын тоо	Хувь
1	Ч.Энхболд	43,154,672	16.66
2	Ч.Амарсанаа	43,154,672	16.66
3	С.Отгонбаяр	43,154,672	16.66
4	Б.Мянганбаяр	43,154,672	16.66
5	Б. Лхагвадорж	43,154,672	16.66
6	Х.Болд	43,154,672	16.66

Б.Хараат бус гишүүнд өгсөн санал:

№	Нэр дэвшигчдийн нэрс	Саналын тоо	Хувь
1	С.Санжаа	43,154,672	38.33

2	А.Батболд	43,154,672	33.33
3	Х.Батхишиг	43,154,672	33.33

Хэлэлцэх асуудал 6:

ТУЗ-ийн 2018 оны цалин урамшууллын төсөв батлах асуудлыг хуралд оролцож байгаа саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчдийн 0% татгалзсан, 0% түдгэлзсэн, 100% зөвшөөрсөн саналаар батлав.

12:10 цагт Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан тогтоолын шийдвэрийг танилцуулан дуусч, хурлын дарга хурлыг хаав.

Хурлын дарга:  

Хурлын протокол хөтөлсөн:  / Д.Шүрэнцэцэг /